



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/304

Улаанбаатар хот

**Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөний
бүрэлдэхүүн, журмыг шинэчлэн батлах
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 2.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөний бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн дэд дарга (Н.Мягмарсүрэн)-д, Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах журмыг мөрдөж ажиллахыг шуурхай зөвлөгөөний бүрэлдэхүүнд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны А/214 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт, 2021 оны А/15 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн дэд дарга (Н.Мягмарсүрэн)-д даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 08 дугаар сарын 16 -ны өдрийн
А/304 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнд
оролцох бүрэлдэхүүн

1. Дэд дарга (Нисэх буудлуудын үйлчилгээ хариуцсан)
2. Дэд дарга (Агаарын навигацийн үйлчилгээ хариуцсан)
3. Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга
4. Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга
5. Дотоод хяналтын албаны дарга
6. Захиргааны хэлтсийн дарга
7. Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын менежер
8. Холбоо, навигаци, ажиглалтын албаны дарга
9. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны дарга
10. Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны дарга
11. "Буянт-Ухаа" нисэх буудлын ашиглалтын хэсгийн дарга
12. Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны дарга
13. Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дарга
14. Аюулгүй байдал, хамгаалалтын албаны дарга
15. Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн албаны дарга
16. "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал (тохиролцсоноор)

---oOo---